



Annual Report 2022

Өөрийн цаг,
энерги, мөнгийг
чухал зүйдээ л
зориул.

Ухаалаг зарцуул.



2022 оны үйл ажиллагааны тайлан

АГУУЛГА

2022 онд Simple	4
Бидний философи, алсын хараа, эрхэм зорилго	5
Бизнесийн тойм	6-7
Санхүүгийн тойм	8-14
Мэндчилгээ	15-16
Бизнесийн үйл ажиллагаа	17
• Зээлийн үйл ажиллагаа	17
• Simple ХБҮЦ	18
• Харилцагчийн үйлчилгээний төв	19-20
Нийгмийн хариуцлага	21
Санхүүгийн үйл ажиллагаа	22
• Орлого, үр дүнгийн нэгдсэн тайлан /аудитлагдсан/	23-25
• Санхүүгийн байдлын нэгдсэн тайлан /аудитлагдсан/	26
Эрсдэлийн удирдлага	27-29
ТУЗ-ийн бүрэлдэхүүн	30
• Шийдвэр, гүйцэтгэл	31
Компанийн бүтэц, зохион байгуулалт	32
• Менежментийн баг	33
• Хүний нөөц	34-35

Сайн уу?

Simple бол сүүлийн үеийн технологи, ухаалаг шийдлийг ашиглан таны цаг, энерги, мөнгийг хэмнэхэд зориулсан хэрэгсэл. Уламжлалт банк бус санхүүгийн байгууллагын үйлчилгээг илүү хялбаршуулж, кредит скоринг системийн

тусламжтайгаар хэрэглэгчийнхээ санхүүгийн чадварт тохирсон зээлийг хамгийн дээд хэмжээ, боломжит хүүгээр санал болгож, зээл олголтын процессыг хүний оролцоогүй, бүрэн автоматжуулсан.

Simple бол таны санхүүгийн найз

Хүн бүрд цаг, мөнгө, энерги гэсэн гурван төрлийн нөөц байдаг. Эдгээрийг ухаалаг зарцуулж байгаа эсэхээс шалтгаалж та ирээдүйд хэн байх нь шийдэгддэг гэдэгт бид итгэдэг. Тиймээс ч бид таны хамгийн сайн санхүүгийн найз байж уг нөөцөө ухаалаг зарцуулахыг үргэлж сануулдаг.

Хэрэглэгчдэдээ зориулсан санхүүгийн зөвлөгөө, контентыг тогтмол хүргэж, өрийн дарамтад оруулахаас сэргийлж зөвхөн шаардлагатай үедээ л зээл авахыг зөвлөсөөр байна.

603k

Апп таталт:

373k

Бүртгэлтэй
харилцагч:

64

Ажилчдын тоо:



Бидний философи

Өөрийн цаг, энерги, мөнгийг чухал зүйлдээ л зориул.



Алсын хараа

№1 Дижитал зээлийн платформ



Эрхэм зорилго

Харилцагчдынхаа цаг, энерги, мөнгийг хэмнэхэд зориулсан санхүүгийн хэрэгсэл байна.

Бизнесийн тойм


2022 онд өмнөх онтой харьцуулахад гэрээтэй харилцагчдын тоо 36%-иар нэмэгдэж 92,5 мянга болсон. Харин бизнес эрхлэгч харилцагчдын нийт тоо 57%-иар нэмэгдэж 254 болон өслөө.

Өнгөрсөн оны хувьд инфляцын өсөлттэй, иргэдийн зээлжих, худалдан авах чадавх багассан хэдий ч

Simple-ийн хувьд харилцагчдад зориулсан зах зээлд нийцэхүйц бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэснээр харилцагч иргэд, байгууллагын тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Цаашид харилцагчдад мөнгөө ухаалаг зарцуулах, цаг, энергиэ хадгалах илүү их боломжийг олгосон бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.


Гэрээт харилцагчийн өсөлт:

36%



Бизнесийн харилцагчийн өсөлт:

57%



Simple апп нь 2022 онд олон нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /ХБҮЦ/ гаргаж, Simple buy бүтээгдэхүүний хүрээнд 12 цахим худалдааны платформтой холболт хийн, 62 мерчант байгууллагын 21,342 бараа бүтээгдэхүүнийг байршуулан харилцагч байгууллага болон иргэддээ Simple апп-аараа дамжуулан бараа, бүтээгдэхүүнээ худалдан авах борлуулах боломж олголоо.

Бизнесийн зээлийн бүтээгдэхүүний хувьд бид ₮1.0 тэрбум хүртэлх зээлийг зах зээлд өрсөлдөхүйц хүүтэйгээр санал болгосон. Үүнтэй зэрэгцээд Хөрөнгө оруулалт санхүүжилтийн зээлийн дээд хугацааг 36 сар болгов.

2023 онд бидэнтэй хамтарч ажиллахыг хүссэн жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа, борлуулалт эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж байгууллагад зориулан санхүүгийн харилцааг хялбарчлах, борлуулалтыг дэмжих зорилготой /BNPL/ шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хэд хэдэн инновацыг гарган нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мөн үүнд Simple апп-аасаа 24 хүртэлх сараар хүссэн хугацаагаа тохируулан итгэлцэл, даатгалын үйлчилгээ авах, үнэт цаасны арилжаа хийх, өөрсдийн зээлжих эрх тооцоолох систем /CS/-ийг бусад финтекүүдэд нийлүүлэх зэрэг үйлчилгээнүүд багтсан байна.

2022 онд авсан шагнал:



Money Market Fund-
Шилдэг ББСБ



ББСБ холбоо- Шилдэг
бүтээгдэхүүнтэй ББСБ



МХАҮТ- Шилдэг инноваци
нэвтрүүлэгч энтрепренер


Санхүүгийн тойм

2020-2023 онд Ашид Капитал ББСБ-ын нийт хөрөнгө жилд дунджаар 2.5 дахин өссөн байна. Үүнд нийт хөрөнгийн 85.4 хувийг бүрдүүлж буй нийт зээлийн өсөлт нөлөөлжээ. 2020 оны 8 дугаар сард үйл ажиллагаа эхлээд 2 жилийн дотор салбартаа нийт хөрөнгөөрөө 2 дугаарт, дижитал зээлийн багцаараа 1 дүгээрт орж байна.

Ашид Капитал ББСБ-ын нийт зээлийн хэмжээ 2022 онд өмнөх онтой харьцуулахад 57 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Нийт хөрөнгө

/тэрбум төгрөгөөр/



Нийт зээл


/тэрбум төгрөгөөр/



Хөрөнгийн бүтцийг харвал 2022 оны байдлаар нийт хөрөнгийн 81%-ийг цэвэр зээл, 16%-ийг мөнгөн хөрөнгө, үлдсэн 3 хувийг богино хугацаат хөрөнгө

оруулалт, үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгүүд тус тус бүрдүүлж байна.


Хөрөнгийн бүтэц /хувиар/



- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Богино хугацаат хөрөнгө оруулалт
- Зээл /цэвэр/
- Хуримтлагдсан хүүний авлага

2022 оны байдлаар нийт хөрөнгийн 70 хувийг өр төлбөр, 30 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

Эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/



- Нийт өр төлбөр
- Эздийн өмч


Санхүүгийн гүйцэтгэл

Сая төгрөг	2020	2021	2022	Өөрчлөлт 21&22
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	31,095	12,028	33,600	179%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-	3,088	100%
Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа	6,499	116,089	182,021	57%
Зээлийн эрсдэлийн сан	(106)	(1,426)	(8,465)	493%
Хуримтлагдсан хүүний авлага	85	1,326	2,282	72%
Үндсэн хөрөгө	8	43	115	168%
Биет бус хөрөнгө	619	556	647	16%
Бусад хөрөнгө	416	1,139	322	-72%
НИЙТ ХӨРӨНГӨ	38,616	129,755	213,610	65%
Бонд	-	25,000	50,000	100%
Хоёрдогч өглөг	-	50,000	50,000	0%
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	-	-	50,000	100%
Бусад өр төлбөр	499	1,414	1,851	31%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	499	76,414	151,851	99%
Энгийн хувьцаа	40,000	55,000	55,000	0%
Хуримтлагдсан ашиг ()	(1,883)	(1,659)	6,759	-507%
ЭЗДИЙН ӨМЧ	38,117	53,341	61,759	16%
ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	38,616	129,755	213,610	65%

ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Ашид Капитал ББСБ нь 2022 онд зээлийн балансыг 57%-иар өсгөсөн нь зээлийн хүүний орлогыг 2 дахин өсөхөд нөлөөлжээ. Тайлант хугацаанд ₮75 тэрбумыг

өрийн бичгээр дамжуулан бусдаас татан төвлөрүүлсэн байна. Тиймээс өмнөх онтой харьцуулахад хүүний зардал 3.6 дахин өссөн.




Ашид Капитал ББСБ-ын нийт зээлийн багцын 70 хувийг дижитал зээл бүрдүүлдэг бөгөөд бид тухайн зээлдэгч дээр зээлийн эрсдэлийг тооцохдоо Зээлийн мэдээллийн сан, Улсын нэгдсэн бүртгэлийн системүүдээс хугацааны алдагдалгүй мэдээлэл солилцон ажилладаг. Тайлант онд зээлийн олголтын хэмжээнээс шалтгаалан дээрх системүүдэд хандсан тоо өссөн.

ББСБ нь тусгай зөвшөөрлийн хүрээнд зохицуулалттай үйл ажиллагаа явуулдаг хэдий ч бүртгэл, тайлагналд санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөж ажилладаг. Зээлийн эрсдэлийн сангийн зардлыг тооцохдоо зохицуулагч байгууллагын шаардлага болон тайлагналын олон улсын стандартын аль алийг нь харгалзан үздэг.

Орлогын бүтэц



Зардлын бүтэц




Орлогын тайлан

Сая төгрөг	2020	2021	2022	Өөрчлөлт 21&22
Хүүний орлого	483	12,754	39,152	207%
Зээл	338	12,124	37,764	211%
Хөрөнгө оруулалт	145	630	1,388	121%
Хүүний зардал	(4)	(3,614)	(16,620)	360%
Цэвэр хүүний орлого	479	9,140	22,532	147%
Шимтгэл, хураамжийн орлого	-	173	647	273%
Шимтгэл, хураамжийн зардал	(4)	(112)	(244)	118%
Бусад орлого	252	(17)	6	-135%
Үйл ажиллагааны нийт орлого	727	9,184	22,941	150%
Эрсдэлийн сангийн зардал	(106)	(1,371)	(7,038)	413%
Нийт үйл ажиллагааны зардал	(2695)	(7,453)	(6,532)	-12%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2074)	360	9,371	2503%
Татварын зардал	191	(136)	(953)	601%
Цэвэр ашиг (алдагдал)	(1883)	224	8,418	3658%

2022 онд цэвэр ашиг ₮8.4 тэрбумд хүрч өмнөх оноос 37.5 дахин өссөн байна.

Цэвэр ашиг /сая төгрөгөөр/



● Цэвэр ашиг (алдагдал) — Цэвэр ашгийн харьцаа

Мэндчилгээ



Бид олон улсад тренд болж буй шинэ технологи, инновацлаг бүтээгдэхүүн, үйлчилгээг амжилттай нэвтрүүлсээр байна.

Б.Билигүүн
ТУЗ-ийн дарга

Хэрэглэгчдийнхээ цаг, мөнгө, энергийг хэмнэхийг үргэлж зорьдог, “Ухаалаг зарцуул” уриатай Simple-чүүд бид 2022 оныг амжилт, ололтоор дүүрэн үдлээ.

Олон улсад тренд болж буй шинэ технологи болон инновацлаг бүтээгдэхүүн үйлчилгээг дотоодын санхүүгийн зах зээлд нутагшуулж, Simple buy буюу одоо аваад дараа төлөх нөхцөлтэй худалдан авалтын зээлийг уламжлалт зээлийн бүтээгдэхүүнтэй хоршуулсан байдлаар зах зээлд амжилттай нэвтрүүлж чадсан.

2022 онд дэлхий дахинд үүссэн нөхцөл байдал бидэнд дотоодын бизнесүүдийн үнэ цэн, ач холбогдлыг хангалттай мэдрүүлсэн билээ. Тиймээс ч бид дотоодын бизнесүүдээ дэмжих зорилгоор бизнесийн зээлийн хэмжээг ₮1 тэрбум болгон нэмэгдүүллээ.

Үүгээр зогсохгүй Simple дэх найзууд нь 2022 онд “Шилдэг бүтээгдэхүүнтэй ББСБ”, “Шилдэг инновац нэвтрүүлэгч” зэрэг шагналуудыг хүртсэн нь энэ жилийн онцлох үйл явдал болсон. 2023 онд ч хэрэглэгчдэдээ зориулсан олон инновацлаг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд улс орны хөгжилд, нийгэмдээ чухал хувь нэмэр оруулсан ажлыг хийхээр төлөвлөж байна.

Simple-чүүд, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, түнш, хамтран ажиллагч байгууллагууддаа 2022 оны санхүү, үйл ажиллагааны тайланг танилцуулж байна. Бидэнтэй санаа бодлоо хуваалцаж, Simple-г хамтдаа бүтээлцэж байгаа харилцагч, хамтрагч нартаа баярлалаа.

Мэндчилгээ



Бид ₮50 тэрбумын Simple ХБҮЦ-ыг анхдагч зах зээл дээр гаргаж, ердөө 2 хоногийн дотор татан төвлөрүүлж Монголын Хөрөнгийн Бирж дээр рекорд тогтоолоо.

П.Батжаргал
Гүйцэтгэх захирал

Уламжлалт ББСБ-ын харилцааг инновацлаг бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн дэвшлээр хялбаршуулж, зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорьсон бидний аялал эхлээд 2 жилийн нүүрийг үзжээ.

Энэ хугацаанд Simple маань 373 мянган бүртгэлтэй хэрэглэгчтэй, үүнээс зээл авсан харилцагчийн тоо 80 мянга гаруй болж чаджээ. Мөн зээлийн багцын хэмжээ ₮200 тэрбумд хүрч, бид нэг жилийн дотор финтекүүд дундаа дижитал зээлийн багцаар тэргүүлсэн амжилтаа хадгалсаар байна.

2022 онд бидний хийсэн хамгийн том ажлын нэг бол Simple ХБҮЦ. Бид Монголын хөрөнгийн бирж (МХБ) дээр өмнө нь байгаагүй, хамгийн өндөр дүнтэй буюу ₮50 тэрбумын Simple Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээл дээр гаргаж, ердөө 2 хоногийн дотор татан төвлөрүүлж МХБ дээр рекорд тогтоосон.

2023 онд хэрэглэгч бүрийн санхүүгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн өөр олон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохоор бид зорьж байна.

Олон улсад финтекүүд санхүүгийн бусад үйлчилгээтэйгээ нэгдэж цогц байдлаар харилцагчдад хүрч байна. Тухайлбал, зөвхөн нэг аппликэйшн ашиглаад даатгуулдаг, зээл авдаг, хөрөнгийн зах зээлээс үнэт цаас, хувьцаа худалдаж авдаг болсон. Үүнийг санхүүгийн бүх бүтээгдэхүүн төвлөрсөн нэг цэгийн үйлчилгээ гэж хэлж болно. Тиймээс бидний алсын хараа ч энэ зүгт чиглэж санхүүгийн зах зээл дээрх бусад тоглогч нартай хамтарч, цогц үйлчилгээ нэвтрүүлэхийг зорьж байна.

Өнөөдрийг хүртэл бидэнтэй хамт байгаа Simple-чүүддээ баярлалаа.

Бизнесийн үйл ажиллагаа

2022 онд бид апп-аараа дамжуулан санхүүгээ ухаалаг удирдах, хамгийн хялбар, ойлгомжтой байдлаар харилцагчид зээл авах боломжийг олгох тал дээр олон төрлийн шинэчлэлт хийн ажилласан.

Үүний үр дүнд бидний бизнесийн гол тоон үзүүлэлт болох зээлийн багцын хувьд өмнөх онуудтай харьцуулахад өссөн эерэг сайн үзүүлэлттэй ба багцын чанарын хувьд сайжирчээ.

Бизнесийн онцлох тоо

	2021	2022
Гэрээтэй харилцагч	12,226	92,505
Бизнесийн харилцагч	162	254
Зээл авсан харилцагчийн тоо	36,961	52,855
Олгосон зээлийн тоо	208,115	367,596
Олгосон зээлийн хэмжээ	₮232,008,130,876	₮406,154,044,771
Зээлийн багц	₮116,088,507,480	₮185,070,188,563

SIMPLE ХБҮЦ

Simple нь Монголын Хөрөнгийн Бирж дээр хамгийн өндөр дүнтэй буюу ₮50 тэрбумын Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргасан. Зах зээлийн эрсдэл өндөр байгаа энэ цаг үед харилцагчдадаа тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүн буюу хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалт болох хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг санал болгож, ердөө хоёр хоногийн дотор татан төвлөрүүлж Монголын Хөрөнгийн Бирж дээр рекорд тогтоож чадсан.

Бид нийт татан төвлөрүүлэх дүнгийн 80% буюу ₮40 тэрбумыг стратегийн хөрөнгө оруулагчдаас, харин үлдсэн 20% буюу ₮10 тэрбумыг олон нийтээс татахаар төлөвлөсөн бөгөөд амжилттай биелүүлж, нийт 266 хөрөнгө оруулагч оролцсон юм.

2022 онд Simple ХБҮЦ хүүний төлөлт хоёр удаа хийгдсэн бөгөөд нийт 252 иргэн, 14 хуулийн этгээдэд ₮3,8 тэрбум төгрөгийн хүү олголоо.



Таны дараагийн хөрөнгө оруулалт

Харилцагчийн мэдээллийн төв

Бид харилцагчдынхаа санхүүгийн туслах, үнэнч найз нь байхын тулд асуулт болгонд хариу өгч мөн тодорхойгүй нөхцөл байдал бүрд нь тусалж, зөвлөхийг хичээн ажиллаж байна.

Харилцагч нартай 1800-2828 тусгай дугаар, и-мэйл, фэйсбүүк пост, коммент, чатаар холбогдон тэднээс ирсэн зээлийн үйлчилгээ, аппликэйшн ашиглалт, бусад үйлчилгээний лавлагааг амжилттай үзүүлж асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.



135,148

Амжилттай үйлчилгээ
үзүүлсэн байдал



43,794

Social сувгаар
үйлчилсэн байдал



32,552

Мессежээр
үйлчилсэн



4,743

И-мэйлээр
үйлчилсэн



78,890

IVR мэдээлэл
авсан



1:53

Ярианы дундаж
минут

Хэрэглэгчид юу хэлэв?



Цагаахан Халгай

Мөнгөний хэрэг гарвал хүнээс зээлэх шаардлага гарахгүй болно гэдэг үнэхээр сайхан байгаа. Хамт олонд нь талархал илэрхийлье. Үнэхээр их хэрэг болдог шүү. Энэ хэрээрээ би ч найдвартай зээлдэгч нь байна кк



Ганхуяг Сугарсүрэн

Ухаалаг зээлээр сайхан санаандаа нийцсэн дуртай хоолоо хийж идэх шарах шүүгээ авсан байгаа шүү.



Ж.Үржинжаргал

Баяр хүргэе танайхаас жил 6 сарын өмнө зээл авсан одоо сайхан байшиндаа сайхан бнаа зөв зохистой хэрэглээний шүү.



О.Сүндэр

Үнэхээр чухал үед санхүүгийн асуудлыг минь минутын дотор шийдэж өгдөг. Баярлалаа танай хамт олонд, амжилт хүсий. Найдавтай зээлдэгч нь



Баярмаа Насанжаргал

Ёстой гоё апп шүү. Даа ялангуяа ухаалаг зарцуул гэдэг үг л хамгийн гоё шт.



Tseegii Flower

Simple-г ашиглаад бараг жил болжээ, ёстой аминд ч орно амьдралд ч нэмэр болдогдоо. Баярлалаа Simple.



Б. Биндэрьяа

Simple байгаагүй бол нээрээ яанааааа 😞😞😞 хайртай шүү сайхан шинэлцгээгээрэй



Simple

Вуууааа, баярлалаа, бид уйлж байна, энэ гэхдээ баярын нулимс шүү Сайхан шинэлээрэй 😊 - Билгүүн

Нийгмийн хариуцлага

Уламжлалт зээлийн аргаар нэг хэрэглэгч зээл авахад дунджаар 2 цаг зарцуулдаг гэж тооцвол бид дижитал зээлийн үйлчилгээ үзүүлж 339 мянган хэрэглэгчийн нийт 678 мянган цаг буюу 77 жилийг хэмнэсэн байна



Нэг удаагийн зээл олголтод дунджаар 15 хуудас цаас зарцуулдаг гэж тооцвол 339 мянган удаагийн зээлийг цахим хэлбэрээр баримт бүрдүүлэхгүй олгосноор 24.4 тонн цаас хэмнэж **610** ширхэг модыг аварчээ.



Бид хэрэглэгчдээ санхүүгээ зүй зохистой удирдахыг үргэлж уриалдаг бөгөөд 2022 онд “Ухаалаг зарцуул”-тай холбоотой нийт 42 контентыг бэлтгэж давтагдсан тоогоор **54,675,200** хүнд дижиталаар хүргэсэн байна.



Хүмүүст эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг мэдээллээр хангах ажлыг дэмжиж NTV ТВ-ээр 7 хоног бүрийн Бямба гарагт гардаг “Вакцин” нэвтрүүлгийг ивээн тэтгэж, хамтран ажилласан.



Machine learning UB community, МУИС хамтран зохион байгуулдаг “Kagglers days” хиймэл оюун ухаан сонирхогсдын тэмцээнийг 2 дахь жилдээ ивээн тэтгэлээ.



Шинэ жилээр харилцагчдадаа өгөх Simple-ийн бэлэгт 100% дотоодын үйлдвэрлэгчдийнхээ үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээс сонгон, худалдан авалт хийж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан.

Санхүүгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн үзүүлэлтүүд	2022	2021
/Мянган төгрөг/		
Нийт актив	213,764,352	129,754,908
Зээлийн багц	186,603,562	116,088,507
Нийт орлого	39,806,827	12,927,051
Цэвэр ашиг	8,593,466	223,848
Нийт актив, пассив	213,764,352	129,754,908
Өөрийн хөрөнгийн өгөөж	13.9%	0.30%

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан 2022/12/31

Мянган төгрөгөөр	2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
Хөрөнгө		
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	29,017,398	11,932,957
Богино хугацаат хөрөнгө оруулалт	3,088,233	95,155
Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа	180,421,001	115,988,348
Бусад хөрөнгө	320,999	639,681
Нийт эргэлтийн хөрөнгийн дүн	212,847,631	128,656,141
Үндсэн хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	114,610	42,782
Биет бус хөрөнгө	647,435	556,379
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	334,483
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	165,123
Нийт эргэлтийн бус хөрөнгийн дүн	762,045	1,098,767
Нийт хөрөнгийн дүн	213,609,676	129,754,908
Өр төлбөр		
Зээлийн өр төлбөр	100,795,098	46,479
Бусад өр төлбөр	631,136	1,365,414
Орлогын татварын өглөг	424,281	37,336
Нийт богино хугацаат өр төлбөрийн дүн	101,850,515	1,449,229
Зээлийн өр төлбөр	50,000,000	74,964,526
Нийт урт хугацаат өр төлбөрийн дүн	50,000,000	74,964,526
Нийт өр төлбөрийн дүн	151,850,515	76,413,755
Эздийн өмч		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	55,000,000	55,000,000
Хуримтлагдсан ашиг/ (алдагдал)	6,759,161	(1,658,847)
Эздийн өмчийн дүн	61,759,161	53,341,153
Нийт эздийн өмч, өр төлбөрийн дүн	213,609,676	129,754,908

Орлого үр дүн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан 2022/12/31

Мянган төгрөгөөр	2022	2021
Хүүгийн орлого	39,152,441	12,754,255
Хүүгийн зардал	(16,620,472)	(3,614,116)
Цэвэр хүүгийн орлого	22,531,969	9,140,139
Шимтгэл хураамжийн орлого	647,108	172,795
Бусад орлого/ (зардал)	10,951	(16,314)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(7,038,459)	(1,370,563)
Үйл ажиллагааны зардал	(6,775,261)	(7,564,683)
Үйл ажиллагааны бусад орлого/ (зардал)	(5,546)	(1,022)
	9,370,762	360,352
Орлогын албан татварын зардал	(952,754)	(136,504)
Тайлант хугацааны цэвэр ашиг	8,418,008	223,848
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлого	8,418,008	223,848

Өмчийн өөрчлөлтийн тайлан 2022/12/31

Мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	Хуримтлагдсан (алдагдал)/ ашиг	Нийт эздийн өмч
2021 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	40,000,000	(1,882,695)	38,117,305
Нийт дэлгэрэнгүй орлого:			
Тайлант хугацааны ашиг	-	223,848	223,848
Хувьцаа гаргасан	15,000,000	-	15,000,000
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	55,000,000	(1,658,847)	53,341,153
2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	55,000,000	(1,658,847)	53,341,153
Нийт дэлгэрэнгүй орлого:			
Тайлант хугацааны ашиг	-	8,418,008	8,418,008
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	55,000,000	6,759,161	61,759,161

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан 2022/12/31

Мянган төгрөгөөр

2022

2021

Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Татварын өмнөх ашиг (алдагдал)	8,418,008	223,848
Тохируулгууд :		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	21,522	9,846
Биет бус хөрөнгийн хорогдуулга	63,230	62,342
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл, хорогдуулга	630,157	351,936
Худалдааны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын гарз/(олзын буцаалт)	7,038,459	1,370,563
Санхүүгийн зардал (цэвэр дүнгээр)	(22,531,969)	(9,140,139)
Валютын ханшийн цэвэр гарз/(олз)	(10,564)	17,239
Актлагдсан бараа материал	37,893	29,186
Орлогын татварын зардал	952,754	136,504
Хөрөнгө болон өр төлбөрийн өөрчлөлт:		
Зээл болон авлагын өсөлт	(70,515,057)	(109,589,358)
Бусад хөрөнгийн бууралт	280,789	750,510
Бусад өр төлбөрийн өсөлт /(бууралт)	(772,125)	605,292
Хүлээн авсан хүү	(15,285,682)	(3,567,638)
Төлөгдсөн хүү	38,037,684	10,142,465
Төлөгдсөн орлогын татвар	(400,686)	(67,045)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(54,035,587)	(108,664,449)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(96,648)	(41,379)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(154,286)	-
Бусад хөрөнгө оруулалтын (өсөлт)/бууралт	(3,000,000)	(95,155)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(3,250,934)	(136,534)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Шинээр гаргасан хувьцаа	-	15,000,000
Авсан зээл	76,500,000	75,000,000
Төлөгдсөн зээл	(1,500,000)	-
Санхүүгийн түрээсийн өглөгийн эргэн төлөлт	(639,602)	(344,085)
Санхүүжилтийн цэвэр мөнгөн гүйлгээ	74,360,398	89,655,915
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)	17,073,877	(19,145,068)
1-р сарын 1-рх мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл	11,932,957	31,095,264
Ханшийн өөрчлөлтийн нөлөө	10,564	(17,239)
12 -р сарын 31-рх мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл	29,017,398	11,932,957

Эрсдэлийн удирдлага

Simple-ийн эрсдэлийн удирдлагын бодлогын зорилт нь бизнест ээлтэй, зохистой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, хэрэгжилтийг хангуулах, хяналт тайлагналтын тэнцвэртэй тогтолцоог бий болгоход оршдог.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАСАГЛАЛ

Эрсдэлийн удирдлагын засаглал нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

Хамгаалалтын гурван бүсийн зарчим нь эрсдэлийг зохистой түвшинд удирдах чиг үүргүүдийг тодорхойлно;

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн цар хүрээ, хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг тодорхойлж, батлах, түүний хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллана;

Хамгаалалтын гурван бүсийн зарчим

Эрсдэлийн удирдлага болон хяналтын тогтолцоондоо хамгаалалтын гурван бүсийн зарчмыг мөрдлөг болгон ажиллана.

Хамгаалалтын нэгдүгээр бүс нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллах бөгөөд өөрийн бизнесийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох бодлого, журам зааврыг хэрэгжүүлэх, эрсдэлийг үнэлэх, хянах, тайлагнах, бууруулж ажиллах чиг үүрэгтэй;

Хамгаалалтын хоёрдугаар бүс нь эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлж ажиллах бөгөөд

Зээлийн удирдлагын хороо нь зээлийн судалгаа, шинжилгээ, дүгнэлтэд үндэслэж шийдвэр гаргах, зээлийн бүтцийг өөрчлөх, барьцаа хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

Эрсдэлийн удирдлагын баримт бичгүүд нь хамгаалалтын гурван бүсийн зарчмыг хэрэгжүүлэх баримт бичгүүд бөгөөд эрсдэлийн удирдлага болон түүнд тавигдах хяналтыг тодорхойлсон байна.

байгууллагын эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог тодорхойлох, эрсдэлийн бодлого журам зааврыг боловсруулах, шинэчлэх, учирч болох эрсдэлийн төрлүүдийг тодорхойлох, тэдгээрийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тогтоох, түүнийг батлуулах, хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй;

Хамгаалалтын гуравдугаар бүс нь хамгаалалтын нэг болон хоёрдугаар бүс эрсдэлийг хэрхэн үр дүнтэй удирдаж байгаа үйл ажиллагаанд хараат бус үнэлэлт дүгнэлт өгч, ТУЗ-д шууд тайлагнан ажиллах чиг үүрэгтэй.

ЭРСДЭЛИЙН ЦАР ХҮРЭЭ, ТӨРЛҮҮД

Бид стратегийн зорилт, бизнесийн төлөвлөгөө, үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн төрлүүдийг дараах байдлаар ангилж, тодорхойлдог. Үүнд:

Зээлийн эрсдэл гэж зээлдэгч зээлийн гэрээний үүргээ цаг тухайд нь биелүүлж чадахгүйн улмаас үүсэх алдагдлыг;

Зээлийн төвлөрлийн эрсдэл гэж хэт их зээлийн төвлөрлийн улмаас үүсэж болзошгүй алдагдлыг;

Зах зээлийн эрсдэл гэж зах зээлийн хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас байгууллагын орлого болон хөрөнгийн хэмжээнд хүлээж болзошгүй алдагдлыг;

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл гэж хязгаарлагдмал өөрийн хөрөнгийн улмаас бизнесийн хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх чадваргүй болох эсхүл зохицуулагч байгууллагын өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж чадахгүй болох эрсдэлийг;

Хөрвөх чадварын эрсдэл гэж байгууллагын өөрийн хөрөнгө хүрэлцээтэй боловч хөрөнгийн өсөлтийг санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдалд орох болон харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох, эсхүл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах нөхцөл байдал үүсэх эрсдэлийг;

ЭРСДЭЛИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

Simple нь үйл ажиллагаандаа эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг тогтоож ажиллах бөгөөд энэ нь стратегийн зорилт болон бизнесийн төлөвлөгөөндөө хүрэхэд учирч болох эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ юм. Өөрөөр хэлбэл хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээгээр эрсдэл хүлээнэ. Эрсдэлийн хэм хэмжээ нь Simple-ийн эрсдэл даах чадварын хүрээнд буюу хууль тогтоомж,

Үйл ажиллагааны эрсдэл гэж дотоод процесс, хүний нөөц болон системийн үйл ажиллагаа хангалтгүй буюу доголдолтой, эсхүл гадны хүчин зүйлийн (үүнд эрх зүйн эрсдэлийн оролцуулан) улмаас үүсэж болзошгүй алдагдлыг;

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл гэж мэдээлэл алдагдах, мэдээллийн системд халдлага хийсний улмаас үүсэх алдагдлыг;

Ёс зүйн эрсдэл гэж байгууллагын ёс зүйн дүрмийг зөрчсөн эсхүл харилцагчидтай шударга харилцах зарчмыг баримтлаагүйн улмаас хүлээж болзошгүй алдагдлыг;

Хянан нийцүүлэлтийн эрсдэл гэж хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт болон байгууллагын ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллаагүйн улмаас үүсэх алдагдлыг;

Нэр хүндийн эрсдэл гэж байгууллагын нэр хүндэд хохирол үүсэх, улмаар орлогын хэмжээнд алдагдал үүсэх эрсдэлийг;

Стратегийн эрсдэл гэж байгууллагын стратегийг оновчтой төлөвлөж чадаагүйн улмаас ашигтай ажиллах, орлогоо олох боломжоо алдах эрсдэлийг ойлгоно.

зохицуулагч байгууллагаас тогтоосон хязгаарлалтын дотор байна.

Мөн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг санхүүгийн эрсдэлийн 17 үзүүлэлт, санхүүгийн бус эрсдэлийн 12 үзүүлэлтээр хэмжин, тогтмол хянан ажиллаж байна.

Эрсдэлийн төрөл		Эрсдэлийн үзүүлэлтүүдийн тоо
Санхүүгийн эрсдэл 17	Зээлийн эрсдэл	4
	Зээлийн төвлөрлийн эрсдэл	8
	Зах зээлийн эрсдэл	2
	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл	2
	Хөрвөх чадварын эрсдэл	1
Санхүүгийн бус эрсдэл 12	Үйл ажиллагааны эрсдэл	4
	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	3
	Ёс зүйн эрсдэл	3
	Хянан нийцүүлэлтийн эрсдэл	2

Зээлийн эрсдэлийн удирдлага

2022 онд бид зээлийн бодлого, журмуудыг шинэчлэн боловсруулж, зээлийн үйл ажиллагааны процесс түүнд тавигдах шаардлагыг бүрэн тодорхойлж, хамгаалалтын гурван бүсийн зарчмыг хэрэгжүүлэх, нэгжүүдийн чиг үүрэг, зээлийн эрсдэлийн удирдлага, хяналтыг сайжруулан ажиллалаа.

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС-9) -д нийцүүлэн ББСБ-ын зээлийн багцын үнэ цэнийн бууралт тооцох аргачлал, заавар журмыг боловсруулан, зээлийн багцын үнэ цэнийн бууралтыг тооцсон.

Бид зээлийн үйл ажиллагаандаа зээлийн өргөдлийн скорингийн загварыг ашиглан харилцагчийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, зээлжих зэрэглэлийг тогтоодог бөгөөд скорингийн загварын үр дүнг буцаан шалгах, шинэчлэн сайжруулах ажил тогтмол хийгдэж байна. Мөн зээлийн эрсдэлийг шинжлэн, зах зээлийн хэвийн болон хэвийн бус

орчинд тооцоолох, зээлийн эрсдэлийг үнэлэх арга аргачлалуудыг сайжруулан ажиллаж байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд төлбөрийн зөрчилтэй зээлийн эргэн төлүүлэлтэд технологид суурилсан шинэлэг арга аргачлалыг нэвтрүүлэн ажилласнаар эргэн төлүүлэх ажиллагааг оновчтой тодорхойлох, зарцуулах хугацааг багасгах, хүний хүчин зүйлээс хамаарсан ажиллагааг багасгах, хөдөлмөрийн бүтээмж болон үр дүнг хэмжих, тайлагнах ажиллагааг боловсронгуй болгов.

Зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн зарчмууд болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, хянах цаашлаад учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийн хяналтын самбар, тайлагналын системийг сайжрууллаа.

Төлөөлөн удирдах зөвлөл

“Ашид Капитал ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 3 гишүүнтэй бөгөөд Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, зохицуулагч байгууллагаас батлан гарсан холбогдох журам заавар болон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

ТУЗ нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4.1-д заасны дагуу жилд

4-өөс доошгүй удаа хуралддаг ба 2022 онд нийт 12 удаагийн хурлаар Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах, Харилцагчдад санхүүгийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах, Хаалттай үнэт цаас болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох, Компанийн бизнесийн төлөвлөгөө батлах зэрэг асуудлыг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг хууль тогтоомжид заасны дагуу гаргаж ажилласан.



Б.Билигүүн
ТУЗ-ийн дарга



Л.Гантөмөр
ТУЗ-ийн гишүүн




Г.Мягмаржав
ТУЗ-ийн гишүүн

2022 оны ТУЗ-ийн шийдвэр, даалгаврын гүйцэтгэл

	Төрөл	Хэлэлцсэн асуудал	Статус
1	Шийдвэр	Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулж, зарцуулах тухай	100%
2	Даалгавар	Зээлийн эргэн төлөлтөө цаг тухайд нь төлөхгүй байх нь тухайн харилцагчид ямар сөрөг нөлөө ирээдүйд үзүүлэх, эсрэгээр цаг тухайд нь төлж байх нь ямар ашиг тус авчрах талаар харилцагчид санхүүгийн боловсрол олгох ажлыг зохион байгуулж ажиллах	100%
3	Шийдвэр	Мөнгөний захын платформд элсэх тухай	100%
4	Шийдвэр	Хаалттай үнэт цаас гаргах	100%
5	Шийдвэр	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангах тухай	100%
6	Шийдвэр	Компанийн дүрэм шинэчлэн батлах тухай	100%
7	Шийдвэр	Төсвийн тодотгол батлах тухай	100%
8	Шийдвэр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох тухай	100%
9	Даалгавар	Equity ашигтай байршуулах боломжийн талаар судалж, танилцуулах	N/A
10	Шийдвэр	Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт оруулах тухай	100%
11	Шийдвэр	Бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай	100%
12	Шийдвэр	Компанийн 2023 оны Бизнес төлөвлөгөө батлах тухай	100%
13	Шийдвэр	Компанийн 2023 оны төсөв, төлөвлөгөө батлах тухай	100%
14	Шийдвэр	Мэдээллийн аюулгүй байдлын бодлого батлах тухай	100%

Компанийн бүтэц, зохион байгуулалт



Менежментийн баг



П. Батжаргал
Гүйцэтгэх захирал



Н. Эрдэнэтунгалаг
Санхүү, бүртгэлийн
албаны дарга



Г. Мөнхбаясгалан
Санхүүгийн удирдлагын
албаны дарга



Б.Сансар
Эрсдэлийн удирдлагын
хэлтсийн захирал



Х. Энхжаргал
Бизнес хөгжлийн
албаны дарга

Хүний нөөц

Бид компанийн эрхэм зорилго, үнэт зүйлс, баримтлах зарчимд тулгуурлан шударга ёс, жендерийн тэгш эрхийг хангасан нээлттэй бодлогыг баримтлан, Монгол Улсын хуулийн дагуу ажилладаг.

Олон ургалч, ялгаатай байдлыг хүндэлж, бүх ажилтнуудтайгаа эн тэнцүү харьцаж, хүн нэг бүрийн хүчин зүтгэл, оролцоог дэмждэг. Шинэ цагийн хөгжил, технологийн дэвшил, дэлхийн чиг хандлагатай хөл нийлүүлэн, тасралтгүй хөгжиж, бие биеэсээ суралцаж, мэдлэг чадвараа ахиулах боломжийг ажилтнууддаа олгохыг зорин ажиллаж байна.

Бидний хэрэгжүүлдэг удирдлагын зохион байгуулалтын хөндлөн (флат) бүтэц нь шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлж, дотоод процессыг илүү уян хатан болгосноор ажлын нээлттэй орчныг бий болгож, ажилтнуудад чөлөөтэй сэтгэх, санал санаачилгаа хэрэгжүүлэх тухтай нөхцөлийг бүрдүүлдэг.

Программ хөгжүүлэлтийн шинэлэг арга барил болох agile аргыг нэвтрүүлж, дэлхийн зах зээл дээрх хамгийн сүүлийн үеийн технологийг цаг алдалгүй өөрсдийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд туршиж, хөгжүүлэлтийн хамгийн оновчтой аргыг нэвтрүүлж, улам бүр сайжруулахаар зорин ажиллаж байна.

- “Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөр”-г хэрэгжүүлж, “Халамжлагч ажилтан”-г томилон ажиллуулснаар багтаа нэгдсэн шинэ гишүүдийг богино хугацаанд дасан зохицоход тусалдаг.

- Тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлснээр байгууллагын чадамжийг нэмэгдүүлэх зорилготой 50 орчим дотоод мэргэшсэн сургагч багш нар мэргэжлийн болон ерөнхий ур чадварын 70 гаруй сургалт зохион байгуулж хамтран ажиллаж байна.

- Компаниас жил бүр байгууллагын үнэт зүйлс, баримтлах зарчмууддаа нийцэж байгаа эсэх, “Ес зүйн дүрэм” ажилтанд хэрхэн бүрэлдсэнийг тодорхойлж, ажилтан хийж буй ажилдаа болон компанидаа хэр сэтгэл ханамжтай байгааг илэрхийлэх зорилготой соёлын судалгаа авдаг. Судалгаанд суурилж, дүн шинжилгээ хийсний

үр дүнд компанийн нэгж бүр сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг.

- Байгууллагын эерэг соёлыг хадгалж, сайжруулснаар ажиллагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилготой чөлөөт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг. Сар бүр хуваарилагдсан нэгжүүдээс санаачилдаг “Хайр ялна” үйл ажиллагаа, өглөөний цайтай уулзалт, цасны баяр, мэдлэг солилцох “Trendy Thursday”, ууланд алхах клуб болон бусад сонирхлын клубийн үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

- Компанийн зүгээс хагас жил тутамдаа “Нэгжийн онцлох ажилтан” шалгаруулж Шангри-Ла спорт клубийн эрхийн бичгээр шагнадаг. Бид бие сэтгэлийн эрүүл мэнддээ анхаардаг соёлыг төлөвшүүлэхийг зорин ажиллаж байна.



64

Нийт ажилтны тоо

28,8

Дундаж нас


53%

Эрэгтэй


47%

Эмэгтэй



 Сэнтрал тауэр, 1 давхар

 1800-2828

 simple.mn

  SimpleMGL